



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/298

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол үндэсний болон орон нутгийн онцлогтой хоол, ундаа сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэх хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын ажилтан нарын ур чадвар, чадамжийг нэмэгдүүлэх зорилгоор Эрдэнэт хотод 05 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Төв бүсийн аварга тогооч, зөөгч шалгаруулах ажил мэргэжлийн уралдаан” арга хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн тогооч, зөөгч нарыг оролцуулсугай.

2. Тус арга хэмжээнд шаардагдах 1,536,040 (нэг сая таван зуун гучин зургаан мянга дөх) төгрөгийг Хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг) нарт зөвшөөрсүгэй.

3. “Төв бүсийн аварга тогооч, зөөгч шалгаруулах ажил мэргэжлийн уралдаан” арга хэмжээнд хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг хангаж, “эмнэлэг сувилал”, “орчин үеийн Монгол хоол”, “ресторан, зоогийн газар, кафе”, “талх, нарийн боов”, “тогооч мэргэжилтэн бэлтгэдэг Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутны төрөл”, шилдэг багийн Гранпри, спорт, урлаг зэрэг 8 төрлөөр зохион байгуулалттай, амжилт үзүүлж оролцуулахыг аймгийн Тогооч хоол үйлдвэрлэл, үйлчилгээний нэгдсэн холбооны тэргүүн (Ш.Отгонхүү)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Сурмаа), аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Саран-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

2122010847

Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дугаар сарын 24 -ны өдрийн
А/298 дугаар захирамжийн хавсралт



ТӨВ БҮСИЙН АВАРГА ТОГООЧ, ЗӨӨГЧ ШАЛГАРУУЛАХ
АЖИЛ МЭРГЭЖЛИЙН УРАЛДААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зарцуулагдах зардал	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Тайлбар
1	/Зуунмод -Эрдэнэт- Зуунмод 1272 км/ Шатахууны зардал /АИ92/	132	литр	2470	326.040	1100 км явна 100 км 12 литр штахуунаар тооцов.
2	Буудал /2 өрөөнд 9 хүн/	3	хоног	80000	240.000	3 хоногоор тооцов.
3	Өдрийн хоол	9	хүн	60000	540.000	1 өдрийн 1 хүний 20000 төгрөг 3 хоногоор тооцов.
4	Хувцасны зардал	10	хүн	28000	280.000	Оролцогч нарын хувцасны зардал
5	Тэмцээний материалын зардал	6	хүн	25000	150.000	Тэмцээнд оролцоогчийн хүнсний зардал
Нийт дүн					1.536.040	

ТӨСӨВ ХЯНАСАН:
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН *И.И.Уу* С.ЦЭЦЭГСҮРЭН

ТӨСӨВ БОЛОВСРУУЛСАН:
АЙМГИЙН ТОГООЧ ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭБДСЭН ХОЛБООНЫ
ТЭРГҮҮН *Ш.ОТГОНХҮҮ* Ш.ОТГОНХҮҮ

